

А. Соловьев



НОНИЧ  
ЗВРРХ





Д. Содномдорж

## ҮНЭНЧ ЗҮРХ

“АРДЫН БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ХЭВЛЭЛ” Улаанбаатар хотноо 1969 онд эрхлэн хэвлүүлсэн номыг Цогт охин тэнгэр сангийн захиалгаар Цагаан бамбарууш хэвлэлийн газарт 2020 онд газарт цахим хэлбэрт хөрвүүлэв.



ЦАХИМ НОМЫН САН: [www.e-nom.mn](http://www.e-nom.mn)

**Найзтайгаа хуваалцаарай:**





**БОЛОР ДУРАН 2.0**  
АЛДАА ШАЛГУУР

## "БОЛОР ДУРАН" ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ ПРОГРАМ

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.





## ЭНЭ НОМЫН УЧИР

Энэ ном салхинаа намирах улаан бүч шигээ жавхлан төгс багачууд та нарын өнөөдрийн аз жаргалтай амьдралын төлөө амь насаа үл хайрлан тэмцэж баатарлаг гавьяа байгуулсан эх оронч хөвгүүдийн тухай ярина. Энэ номын баатрууд

«...Үүл нүүж цахилгаан бадарсан талбарт үер бууж сүрийг үзүүлсэн газар хэзээнээс алдартай дархан хилийн овоо, хэн ч халдашгүй монголын нутаг...»-аа өмгөөлөн хамгаалахын төлөө ширмэн бөмбөг дор, аянгын суман дунд пулемётын амыг цээжээрээ таглан явж хойч үе та бидэндээ үлгэрлэн дуурайх баатарлаг зам мөр үлдээсэн юм. Эх орон ард түмэндээ хайрлагдсан энэ алдарт баатруудын тухай сэдэв тус бүр хэчнээн том зохиол туурвих зохиолчдоо хүлээж байгаа юм. Гэвч Д. Содномдоржийн энэхүү ном бол БНМАУ-ын 10 гаруй баатруудын онцлог ялалт баатарлаг үйлсийг яруу найргийн олон хэлбэрээр гаргасанд оршино.

Манай нам засгаас ахмад үеийнхний хувьсгалт баатарлаг хөдөлмөрч уламжлалаар залуу үеийг хүмүүжүүлэх тухай асуудлыг онцгой анхаарч буйн үрээр манай өсвөрийн үеийнхэн ч цэвэр ариунаар өсөн бойжиж байна. Үүний өмнө «Навсайдамба түүний нөхөд» хэмээх номтой учран золгосноо та нар санаж буй биз ээ.

Тэрхүү ном хувьсгалт засаг төрийг эсэргүүцсэн харгис хүчний эсрэг манай хүүхдүүд хэрхэн тэмцэж байсныг гаргасан бол энэ номд тусгаар тогтносон эх орноо хамгаалсан эрэлхэг баатруудыг үзүүлнэ.

*Ж. ШАГДАР*

*Хүүхдүүдтэй харилцан чин сэтгэлийн угаас ярилцах маягийн богино  
шүлгүүд*

## ОРШИЛ БЯЦХАН ШҮЛЭГ

Багачууд аа! Би та нартаа  
Байлдааны тухай, ярих гэж байна.  
Байлдааны тухай ярихаар барахгүй  
Баатруудын тухай бичих гэж байна  
Баатруудын тухай бичээд ч зогсохгүй  
Баатарлаг гавьяаг нь хэлэх гэж байна.  
Баатарлаг гавьяаг нь хэлээд ч зогсохгүй  
Байгуулсан ялалтыг нь магтах гэж байна  
Байгуулсан ялалтыг нь магтаад ч зогсохгүй  
Бахдал болгон дуурьсгах гэж байна.  
Бахдал болгон дуурьсгаад ч зогсохгүй  
Бахархал болгон дуулах гэж байна  
Бахархал болгон дуулаад ч зогсохгүй  
Багачууд та нарыг итгүүлэх гэж байна.

## ТЭР ЦАГ, ДАЙНЫ-ҮЕИЙН ХҮҮХДҮҮДИЙН ЗӨГНӨЛ ТОГЛООМЫН ТУХАЙ ӨӨРӨӨРӨӨ ЖИШЭЭ ТАТАН ШҮЛЭГЛЭХ НЬ

Би

эх орноо хамгаалахаар  
байлдаанд яваагүй

Би

эгэл олноо өмгөөлөхөөр  
байлдагч байгаагүй

Харин

байлдааны ард  
хамгаалуулж байснаа  
санах юм бол нь

Харин

байлдагчийн хүчээр  
өмгөөлүүлж явснаа  
бодох юм бол нь

Хорин есөн

жилийн өмнө  
аравтай байхдаа

Хонины бэлчээрээс

холдож үзээгүй  
балчир ахуйдаа

Хотныхоо хүүхдийг

цуглуулж байгаад  
«байлдаж» наадахдаа

Хоёр хэсэг

хуваагдаж салаад  
«дайтаж» тоглохдоо

Торхны бүсэн сэлэмтэй

байлдагч байснаа  
санаж байна.

Тоглоомын модон буутай

«дарга» ч явснаа  
дуурьсаж байна.

Улаан дарцагхнаа



туг болгож  
    салхинаа хийсгээд  
УРА! хашхиран  
    дайралт хийж  
        давшиж байхдаа  
«Устгахыг» нь «устгаж»  
    «Ухрахыг» нь «ухрааж»  
        ялж явахдаа  
«Урвасныг» нь байцааж  
    «унасныг» нь баривчилж  
        дийлж байхдаа  
Дариар биш ээ  
    амаараа л буудаж  
        худлаа үхүүлсэн.  
Мориор биш ээ  
    хөлөөрөө л гүйж  
        хурдлан атакалсан  
Цусаа биш ээ  
    хөлсөө л урстал  
        «байлдаж» явсан.  
Цуутай нэгэн  
    бяцхан «байлдагч»  
        байсан юм даа.  
Тэгж л бидний  
    байлдаж явсан нь  
        тоглоом ч гэлээ  
Тэр үе,  
    цагийн байдалтай  
        тохирч байжээ,  
Тэрсүүд дайсан  
    эх орныг минь  
        эзлэх гэж  
Тэнэгэр сайхан  
    эрх чөлөөг минь  
        эвдлэх гэж  
Хил хязгаараар  
    нэвт шургах гэж

оролдож байсан  
Хэн нь чухам  
түрүүлэх нь вэ гэж  
уралдаж байсан  
Түрэмгий дайснууд  
удаа дараагаар  
өнгөлзөж байсан  
Түгшүүр зарласан  
хүнд цагууд  
байлаа шүү дээ!  
Түм түмэн  
цэрэг эрс  
өөдөөс нь сөрж  
Төмөр хэрэм шиг  
эгнэн угтаж  
өмнөөс нь өрж  
Байлдаж, ялж  
баатарлаж байсан  
цаг болохоор  
Багачууд бидний  
тэгж тоглодог нь  
зөв л байж дээ.  
Ухаандаа би  
том болж  
цэрэгт очоод  
Улаан армийн  
байлдагч болж  
дайсантай тулаад  
Балмад тэднийг  
бут цохиж  
салам хөөхийгөө  
Багаасаа бэлтгэж  
байлдаанд орохыгоо  
зэхэж л байж дээ  
Хэдий ингэлээ ч  
багачууд биднийг  
том болгож

Хэрвээ байлдвал  
баатарлан ялах  
цэрэг байлгахыг  
Ардын арми  
хүлээсэн ч үгүй  
хүссэн ч үгүй  
Атаатнаа дарж  
Ардаа амаржуулж  
алдраа мандуулжээ.  
Цэрэг болгож  
Байлдаанд оруулахын оронд  
Цүнх бариулж  
Сургуульд явуулахыг зорьжээ.  
Буу үүрүүлж  
Дайсанд галлуулахын оронд  
Үзэг атгуулж  
Эрдэмд шамдуулахыг зэхжээ  
Ингэж бидний  
баатарлаж явсан нь  
бага хэрэг ээ!  
Энийгээ ер нь  
бахархаж ярихаа  
байзнаж тогтёё.  
Харин тэнд  
жинхэнэ байлдаж  
ёстой дайтсан  
Халхын голд  
жинхэнэ баатарлаж  
ёстой ялсан  
Үлэмжийн гавьяат  
золбоот эрсийн  
хөшөөнд ёсолцгооё!  
Үргэлжийн алдарт  
зоригт хөвгүүдийн  
хөрөгт мэхийцгээе!

**БИД ЗҮВ ЗҮГЭЭР БАЙСААР АТАЛ ДАЙСНУУД ЯАГААД ӨДӨЖ  
СӨДӨӨД ДАЙРЧ ДАВШЛААД, ДОВТЛООД БАЙСАН ЮМ БЭ?  
ГЭСЭН СЭДВЭЭР ШҮЛЭГЛЭХ НЬ**

Эх орон маань  
Уудам цэлгэр учраас  
Эрх чөлөө маань  
Улам дэлгэр учраас  
Энх амьдрал маань  
Хавтай ханагар учраас  
Эзэн түмэн маань  
Тавтай жаргалтай учраас  
Дайснууд  
Нүд үзүүрлэн  
Атаархдаг байв.  
Дайснууд  
Шүд хурцлан  
Жөтөөрхдөг байв.  
Дайснууд  
Байж ядталаа  
Хорсдог байв.  
Дайснууд  
Багтартлаа  
Уурсдаг байв.  
Нутаг дэвсгэр нь  
    өөрсдөд нь багадаагүй  
        багтаад л байсан мөртөө  
Нуур голуудынх нь  
    ус нь барагдаагүй  
        бялхаад л байсан мөртөө  
Тарианы нь талбай  
    хомсдоогүй, давчуудаагүй  
        хүрээд л байсан мөртөө  
Талхны нь гурил  
    ховордоогүй хорогдоогүй  
        болоод л байсан мөртөө

Биднээс илүү  
цэлгэр нутагтай  
байна гэнэ ээ гэж  
шүдээ хавируулаад  
Биднээс илүү  
дэлгэр эрхтэй  
сууна гэнэ ээ гэж  
шүлсээ савируулаад  
Биднээс дээгүүр  
аж амьдралтай  
байна гэнэ ээ гэж  
хөмхийгөө зуугаад  
Биднээс дээгүүр  
аз жаргалтай  
явна гэнэ ээ гэж  
хөмсгөө зангидаад

Тэр уудам нутгийг чинь  
Эзлэх юм хун даа гэж  
Тэгш эрх чөлөөг чинь  
Эвдлэх юм чинь дээ гэж  
Тэнэгэр саруул амьдралыг чинь  
Бусниулна даа гэж зангаад  
Тэлгэр аз жаргалыг чинь  
Булаана даа гэж зүхээд  
Өөрсдөө үүрч даамгүй  
Чирч дийлэмгүй  
Зэвсгээр хуяглагчаад  
Өмнөөс  
Урдаас  
Баруунаас  
Өчнөөн төчнөөн  
Дайрч давшилж байсныг  
Түүх та нарт бэлхнээ  
Түмэнтээ ярьсан болохоор  
Түүнийг би дахин давтаж  
Бумантаа шүлэглээд яах вэ?  
Хэрэв тэдний хүсэл санаа

Хэрэгжин биелж бүтсэн сэн бол  
Төрөлх монгол ямар байхыг  
Төсөөлж бодоход хэцүүгүй ээ  
Бүгд найрамдах  
Монгол Ард Улс гэж  
Бүх дэлхийн  
Аль ч бөөрөнд байхгүй сэн  
Энэ уудам нутгийг маань  
Дайснууд зоргоороо талхидаж  
Эзэн түмэн ардыг маань  
Дарлан зовоон талхидаж  
Та нар маань  
Сурах сургууль ч үгүй  
Судлан унших ном ч үгүй  
Танайх чинь суух байргүй  
Гудмын дунд хоноглоно.  
Аав нар чинь  
Ажилчин ч биш  
Малчин ч биш  
Сэхээтэн ч биш  
Ээж нар чинь  
Эмч ч биш  
Эрдэмтэн ч биш  
Оёдолчин ч биш  
Ах нар чинь  
Тракторч ч биш  
Жолооч ч биш  
Нисгэгч ч биш  
Эгч нар чинь  
Багш ч биш  
Инженер ч биш  
Нэхмэлчин ч биш  
Та нар чинь  
Сурагч ч биш  
Пионер ч биш  
Ажил хөдөлмөр ч үгүй  
Алдар гавьяа ч үгүй

Авдаг цалин ч үгүй  
Ачилдаг хүн ч үгүй  
Арчаагаа бүр алдсан  
Зарц нар байж  
Чадаа ч уу? үгүй ч үү?  
Амьдарч цөхөж ядсан  
Боол нар байж  
Дөнгөө ч үү? үгүй ч үү?  
Бүү мэд  
Бүү үзэгд  
Гэвч  
Дайсны тэр хорон санааг  
Манайхан,  
Манайхан шүү дээ  
Няцаасан ч  
Бут цохисон ч  
Дайсны тэр хомхой сэтгэлийг  
Манайхан  
Манайхан шүү дээ.  
Буцаасан ч  
Няц нүдсэн ч...



## ОДОО БАЙЛДААН ГЭЖ ЮУ БОЛДОГ, БАЙЛДААНД МАНАЙХАН ХЭРХЭН ЯЛДАГ БАЙСАН ТУХАЙ ЦААШ ШҮЛЭГЛЭЕ

Аяа... байлдаан... байлдаан...  
Аймшигт байлдаан... дайн байлдаан  
Хүн төрөлхтөнд  
Хэчнээн удаа тохиолдов оо?  
Хүж дэлхийнхэн  
Хэчнээн удаа дайтав аа?  
Бүр эрт цагаас эхлээд  
Бүдүүлэг харанхуй үеэс аваад  
Бие биеэ номхотгон  
Дагуулах гэж өрсөлдөж  
Бие биеэ ноёлон  
Дарлах гэж тэрсэлдэж  
Хуяг дуулгаа өмсөцгөөж  
Хурц сэлэм агсацгааж  
Бамбай, жад, нум сумаар  
Балбалдаж дайтаж иржээ.  
Хаан Наполеон  
Харгис Чингэс  
Дэлхийг түйвээн  
Дээр нь оршсон  
Хүн төрөлхтнийг түйвээж  
Хаад ноёд  
Эрх, ямбаа  
Эхнэр, хатдаа булаацалдаж  
Ашиг тусаа олоогүй  
Ач гавьяаны нөлөөгүй  
Олон олон, дайн тулаан  
Орчлонгийн талбар дээр болжээ.  
Бүр саяхан  
Бүх дэлхийг  
Ганцхан гүрэн эзэлнэ гэж  
Гитлер их санаад...  
Ялагдсан...

Ялаа хүлээсэн...  
Одоо ч гэсэн  
Орчлонгийн өнцөгт  
Өнөөх л хар байлдаан  
Улс гүрэнд болж л байна.  
Улаан цус урсаж л байна  
Хүйтэн зэвсэг шагайлцаж л байна.  
Хүн нь хүнээ алж л байна  
Гэвч хүүхдүүд ээ битгий ай  
Гэгээн Зөвлөлт орон байна.  
Гэмгүй ариун санаатан байна.  
Гэмтэн биднээс олонгүй байна  
Үхээрийн хар дайныг  
Үүрд зайлуулахын төлөө  
Үзэшгүй тэр дайсныг  
Үгүй хийхийн төлөө  
Саруул ертөнц тэмцэж байна.  
Санаа сайтан дэмжиж байна.  
Тэр дайныг тогтоон барих  
Тийм чөдөр манайханд байна.  
Тэр дайныг тонилгон баллах  
Тийм чадал манайханд байна.  
Дайн болно гэж санасны хэрэггүй  
Давагдаж дийлэгдэнэ гэж бодсоны ашиггүй  
Дайн болно гэж айхын оронд харин  
Давтлага хийхгүй, шалгалтад орж  
Сул дүн тэвэрчих тийм аюулаас л  
Сурагч бүр эмээж явах хэрэгтэй.  
Гэвч сонор сэрэмж хэрэгтэй  
Гэнэт дайсан довтолдог юмаа гэхэд  
Эх орон, эгэл түмэн, энх амьдралаа хамгаалах  
Эрэлхэг зориг, чин санаа хэрэгтэй.

Халхын гол —  
Хамар даваа  
Баян цагаанд  
Хар утаа —

Харанхуй манан  
Хахаж цацам май  
Дарийн хэншүү хярвас  
Хүхрийн эхүүн үнэр —  
Газар, тэнгэр нийлж  
Галав юүлэх шиг нижигнэж  
Шороон түмэн дайсан  
Шоргоолж адил байсан  
Энд ч бөмбөг шүнгэнэж  
Тэнд ч сум сүнгэнэж  
Түүгээр ч хуягтууд хөлхөж  
Үүгээр ч танкнууд мөлхөж  
Дээгүүр ч онгоцнууд дүнгэнэж  
Доогуур ч машинууд хүнгэнэж  
Моторын дуу үргэлжилж  
Морин туурай тачигнаж  
Хүнийхэн манайхан хоёрын  
Хүч чадал соригдож  
Хүйтэн сумнууд солбилцож  
Хэн хэнийхээ цэргийн  
Хэнхдэг цээжийг нүхлэлцэж  
Улалзаж шатсан  
Дайны гал түймэр  
Мана болж байхад  
Улайсаж халсан  
Зэвсгийн гол төмөр  
Мах болж байхад  
Манай улаан цэргүүд  
Маньгаа хамгаалахын төлөө  
Биднийхээ өмнө зэрэгцэж  
Биеэрээ бамбай болон хэрэмлэж  
Тэр олон дайсны өмнөөс  
Тэнгэрийн мөндөр шиг сумны өөдөөс  
Онгорой, онгорой буунуудын  
Амыг чиглээд  
Онилсон шагайсан овоо харааны  
Голыг зүглээд

Алхам ч ухраагүй  
Арагшаа ч хараагүй  
Уухайлан дайрч  
Улайран давшилж  
Монгол цэрэг эрсийн  
Мохошгүй зоригийг илтгэсэн  
Мянга түмэн баатруудын дундаас  
Мятаршгүй чин зоригтны дотроос  
Цөөн хэдийг бичнэ үү гэхээс  
Цөмийг нь би яахан барах вэ?

**ОДОО ОМОГТ НИСГЭГЧ, ДОМОГТ БААТАР ДЭМБЭРЭЛ,  
ОГТОРГУЙД ЯАЖ БАЙЛДАЖ ЗОРИГТ ШОНХОР БОЛСОН ТУХАЙ  
ШҮЛЭГЛЭЭ**

Талыг хучсан цасны  
Сүүлчийн зайрмаг уусаж  
Тачир зулзаган ногооны  
Түрүүчийн үзүүр цухуйж  
Тааламжтай сайхан хаврын  
Наран хурцаар ивээсэн  
Тамсагбулагийн тэнгэр  
Толин цэнхэр мэлтийжээ.  
Байгаль орчин ийм л  
Амар жимэр налайхад  
Байдал зохис тийм л  
Айвуу тайвуу дүнсийхэд  
Хэний ч сэтгэл ер нь  
Амгалан байж болдог ч  
Хил хавийн цэргүүд  
Омголон сонор байдаг юм.  
Хүчит моторын дуун  
Хүнгэнэлдэн дүнгэнэж  
Хүний нутгийн зүгээс  
Хүврэлдэн цувралдаж  
Гурав дөрвөн онгоцоор  
Агаар дээрээсээ хамгаалуулж  
Гудиггүй шунахай дайсан  
Ахиад л бас довтолжээ.  
Уулын орой дээр гарч  
Хэн ч даллаагүй байтал  
Урилга заллага илгээж  
Хэзээ ч дуудаагүй атал  
Дур зоргоороо шургалсан  
Хомхой шунаг дайсныг  
Духыг нь сумаар цохдож  
Нэгийгээ үзэхээс яах вэ?

Эх орныхоо хил рүү  
Цөмрөн орсон тэднийг  
Энх олныхоо зүг рүү  
Нөмрөн ирсэн эднийг  
Агшин зуурт сөнөөх  
Эрхэм хүндэт даалгавар  
Эрэлхэг нисгэгч Дэмбэрэлд  
Энэ удаа ноогдсон юм.  
Онгоц хөлгөө жолоодож  
Зоригт шонхор нисэж л дээ.  
Огторгуйн мандалд хөөрч  
Зохих өндрөө авч л дээ  
Дороо байгаа дайсныг  
Тэнгэр дээрээс бөмбөгдлөө л...  
Дэргэдээ яваа онгоцнуудыг нь  
Тэс хөндлөнгөөс галлалаа л...  
Давуу хүчтэй дайсан ч  
Даруй галаа нээж л дээ.  
Гучаад машинтан дороос нь  
Гурван онгоцтон хажуугаас нь  
Ширмэн мөндөр цацалж  
Ширүүн бороо шиг шүршиж  
Ганцхан, нисгэгч Дэмбэрэлийг  
Галынхаа хүрээнд оруулсан юм.  
Харийн дайсан японы  
Хамгийн дөмөг онгоцнууд нь ч  
Хар утаа баагиулсаар  
Харваж доошоо унажээ.  
Газраар явсан цуваанууд  
Өм цөм бөмбөгдүүлж  
Гал түймэр дүрэлзүүлж  
Энд тэндгүй шатжээ.  
Дэмбэрэл шонхрыг буудсан  
Дайсны түмэн сум  
Дээр асарлах тэнгэрийн  
Хий хоосонд сульдаж  
Эргэж доош унахдаа

Гунигтай нь аргагүй ойчиж  
Эх орны маань шороонд  
Зэврэн шигдэн хэвтсэн юм.  
Гал шиг халуун зүрхтэй  
Дамчайн хүү Дэмбэрэл  
Ган шиг хатуу зоригоо  
Дайсанд бэлхнээ гайхуулж  
Овоо хараанд нь өртөлгүй  
Дээш, доошоо годройтож  
Олон суманд нь оногдолгүй  
Дийлж тэднийг давжээ.

*БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн  
1936 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 13 дугаар хурлын тогтоолд  
«...агуу баатарлаг зориг гарган дайсны омог хүчийг мохоон,  
Ардын Хувьсгалт цэрэг, эх орноо батлан хамгаалж чадах хүчин  
мөнийг товойлгон үзүүлсэн нь сайшаалтай» гэж тэмдэглээд  
Сэлэнгэ аймгийн харьяат Дамчайн Дэмбэрэлийг БНМАУ-ын  
агаарын зоригт баатар цол шагнажээ.*



## ОДОО ГОНГОР ГУАЙ ЯАЖ ДАЙСНЫГ ДАХТАЙГАА БАЙЛДУУЛЖ ДАМШИГЛАЖ ЯЛСАН ТУХАЙ ШҮЛЭГЛЭЭ

Та нарын дотор Гонгор гуайг  
Таньдаггүй хүүхэд байна уу?  
Сонин аргаар байлдсаныг нь  
Сонсоогүй жаалууд бий юү?

Гонгор гуайн нэг онцлог бол  
Гоц мэргэн бууддаг юм.  
Тэртээд босгосон харандааг байтугай  
Тэвнийн сүвэгчээр гаргах хүн

Бага наснаасаа анд хорхойтож  
Баянхутагийн уулсаар хэрж  
Сүргийн дайсан чоныг авласан  
Сумын нэртэй анчин байсан юм

Хориод насандаа цэрэгт мордож  
Хотол гүрнийхээ хилийг манаж  
Халхын голоос нэр нь түгсэн юм.  
Харуулын цэргээс зар нь тарсан юм.

Сүргийн дайсан чоныг авласан  
Сумын нэртэй анчин байсан бол  
Хүний дайсан Японыг авласан  
Улсын нэртэй баатар болсон юм.

■

Царгиа хүйтний эрч гаарч  
Цангинам жавар магнай ташна.  
Цагаан нэхий дээл жиндүүлж  
Цасан шуурга нүдгүй балбана.

Эх орныхоо торгон хилийг  
Эндэлгүй байлгах эрхэм үүрэгтэй  
Эрэлхэг гурван хилчин залуу

Энэ шөнийн манаанд гарав аа.

Башир аргатай этгээд дайсан  
Байгалийн ийм бэрхийг ашиглаж  
Хойноос, зүүнээс, урдаас  
Хоншоор цухуйлгаж юуны магад.

Соргог хурц хараатай байж  
Сонор сэрэмжээ өндөр байлга!  
Бага дарга Гонгор ингэж  
Байлдагч хоёр нөхөртөө тушаав.

Давшиж ирвэл, тосож байлдахаар  
Дайсанд буугаа хэзээд бариастай  
Гол төмөрт нь сум хийгээстэй  
Гох дэгээнд нь хуруу зэхээстэй

Итгэлт хилчид зургаан нүдээ  
Ирмэхийн төдий ганц ч цавчилгүй  
Торгон хилээ соргогоор ажиглана,  
Товгор хотгорыг сэргэгээр сэжиглэнэ.

Сүртэй шуурга жаахан саарч  
Сүүл хэрдээ омог нь буурч  
Үүлтэй тэнгэрийн зүүн хаяаг  
Үүрийн гэгээ алгуур сөхлөө.

Тэгтэл тэндээс харлан бараалж  
Тэмээтэй, морьтой нь мэдэгдэмгүй  
Арваад тооны бөөн хар юм.  
Ахисаар, дөхсөөр байна гэнэ шүү.

Гурван хилчин зогтусаж  
Гурвуул мориноос үсрэн бууж  
Амдан тосож бөхийн гүйсээр  
Ашигтай байраа сонгон хэвтэв.

Хилчин Гонгорын холч дурангийн  
Хэрээс-зураастай хараан дотор

Морио хөтөлсөн самуурай «зочид»  
Морилон айсуй нь тодхон харагдав.

Байдал иймийг нэгэнт ажиж  
Байлдаж тулалдахаар Гонгор амжиж  
Байлдагч Очирыг холбоочноор буцааж  
Базарсаддаа морио бариулж

Гурван дахаа хүн хэлбэрээр  
Гулгуурын дээгүүр эгнүүлэн босгов.  
Гулсан гэтэж байр сэлгээд  
Ирсэн дайсныг унагаж гарав.

Дайснууд сандран галаа нээж  
Дахнуудтай нь байлдаж эхлэв.  
Баахан сумаа арьсанд шидэж  
Бархиран хашхиран давшиж байв.

Үхэж өгдөггүй гурван дах  
Үй түмэн нүхтэй болов.  
Хэчнээн буудуулсан ч ямааны арьс  
Хэвээ яаж өөрчлөх бил ээ?

Гонгор, тэднийг сум тоолон  
Гох мултлангуут газардуулж байв.  
Ганцаар арвыг сөнөөн дарж  
Гавьяат үйлсээ түүхнээ мөнхлөв.

*...Нам, засаг, эх орон, ард түмэндээ хязгааргүй хайртай өргөсөн  
тангарагтаа үнэнч байж баатарлаг гавьяа байгуулсан Хэнтий  
аймгийн Буян хутаг сумын харьяат Шагдарын Гонгорт БНМАУ-  
ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1936 оны 1 дүгээр сарын 29-ний  
өдрийн 4 дүгээр тогтоолоор БНМАУ-ын баатар цол шагнажээ.*

## ОЛЗВОЙ ТАГНУУЛЧ ЯАЖ ОНЦГОЙ ДААЛГАВАР БИЕЛҮҮЛЖ ЯПОН ЦЭРЭГ БОЛЖ, ЯНДАН ДУРАН АВЧИРСАН ТУХАЙ ШҮЛЭГЛЭЭ

Тэгэхэд би найман настай байлаа  
Тэр намар сургуульд орохоор бүртгэгдлээ.  
Тэрсүүд японтой манайхан тулалдаж байлаа,  
Тэрнийг би битүүдээ мэддэг байлаа.

Аюулт дайсныг барьж авчирсан  
Аймшиггүй хүн гарч гэж сонсоод  
Тэсгэлгүй их гайхан бишрэв.  
Тэр нь харин Олзвой байв.

Сүүлд би ухаан суугаад  
Сүрхий сонирхон, түүнийг судалж  
Олзвой баатрын зоригийг илтгэсэн  
Олон ном уншсан билээ.

Түүний баатарлагийг бичнэ гэвэл  
Түмэн хуудас шүлэглэж болно.  
Түүн дундаас нэгэн учралыг  
Түүж бичвэл зүйтэй санагдана.

■

«Байлдагч Олзвой над дээр» гэсэн  
Хороон даргын тушаал хүнгэнэв.  
Бахиал гутлын өсгий хавсран  
Хоромхон зуур ёслол зогсов.

Олзвой тагнуулч, өөрийн даргаас  
Онцгой даалгавар хүлээн авлаа.  
Эх орны нь нэрийн өмнөөс  
Энэ тушаал түүнд өгөгдлөө.

Тагнуулч хүнд оногдсон үүрэг  
Та нарын мэдээж хүнд шүү дээ

Хүнд даалгаврыг биелүүлнэ гэдэг  
Хүний дээд гавьяа шүү дээ

Сэхээ самбаа хэрэгтэй юу?  
— Мэдээжийн  
— Сэргэг соргог хэрэгтэй юү?  
— Бодоожийн  
— Зүрх зориг хэрэгтэй юү?  
— Яриангүй  
— Зүтгэл золбоо хэрэгтэй юү?  
— Хэлэлцээнгүй

Хэрэг тохиолдвол  
Дайсантай адилхан  
Дайсан болж хуурах,  
Хэрэв шаардагдвал

Даргатай нь ижилхэн  
Дарга нь болж мэхлэх  
Хэрэгцээ гарвал  
Өөрсдийнхөн рүүгээ ч

Худлаа буудаж залилах  
Хэцүү цаг  
Тагнуулч хүнд  
Байдаг л юм даа хүүхдүүд ээ!

■

Харанхуй шөнө дүнсийсээр  
Хагас хувь нь өнгөрөх нь  
Хариугүй одоо ингэсхийгээд  
Хаяан талаасаа өнгө орох нь

Бүгд бүгдээрээ үхсэн юм шиг  
Бүхэл бүхлээрээ биесээ дэрлэн  
Хуаран байрандаа дайснууд  
Хурхиран яраглан унтацгаана.

Улаан цэргийн галд сүйрч  
Хадсан өвс шиг наллаа гэж  
Урт Халхын голд үйж  
Хатсан навч шиг хөвлөө гэж

Монгол цэргийн давшилтад  
Амь зулбан зугтлаа гэж  
Морин аттакийн дайралтад  
Арга барагдан баригдлаа гэж

Хоёр гараа өргөцгөөгөөд  
Хойноосоо туугдан явлаа гэж  
Хосгүй хүчинд нь автан  
Хороо хороогоороо буулаа гэж

Хар даран зүүдэлсээр  
Хашхичиж зарим нь дэмийрсээр  
Хамаг хөлс нь дааварласаар  
Хажуу бөөрөөрөө хөрвөсөөр аж.

Япон манаач буугаа барин  
Ёрдгор жадыг нь гозолзуулаад  
Хойш урагшаа холхин явна.  
Хоолой засан, хааяа эвшээнэ.

Ам нь харлан онгойсон  
Агаар шорлон олийсон  
Тоонон чинээ дугуйтай  
Томоо гэгчийн их буунууд

Хажуу хажуугаа нийлүүлээд  
Ханаран эгнэж зэрэглээд  
Харахад эвгүй санагдана.  
Хавьтахад тавгүй бодогдоно.

Дайсны ангийн хаяанд  
Давшиж очсон Олзвой  
Энэ бүхнийг ажиглана  
Эргэн тойрноо сэжиглэнэ

Зориг шийдэн аяар мөлхсөөр  
Зогсоо манааг араас нь дайрч  
Бархирахын завдгүй амыг нь барьж  
Бадируун гараараа унатал дэлсэв.

Унахын чацуу түүнийг өргөн  
Уруудан гүйж хонхорт ирэв.  
Нөхөртөө тушааж хувцсыг нь тайлаад  
Нөгөө манаачийн оронд зогсов.

Хуучирч муудсан түүнийг нь өмсөөд  
Хутган жадтай бууг нь бариад  
Их бууч япон цэргүүдийн  
Итгэлт манааг чадамгай орлов.

Урагш хойш холхин хэрж  
Унтаа цэргийн багцааг мэдэж  
Их бууных нь тоог тэмдэглэж  
Итгэлт яндан дуранг нь олзолж

Япон цэргээ мориндоо дүүрээд  
Яндан дуранг нь мөрөндөө үүрээд  
Үүрийн цолмон гялалзаж байхад  
Үүргээ биелүүлээд ангидаа ирэв.

*Олзвойн халуун эх оронч үзэл, хатан зориг мятариггүй зүтгэлээр эх орон, ард түмнийхээ өмнө байгуулсан яруу алдарт гавьяаг нь үнэлэн БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1939 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор Ховд аймгийн Манхан сумын харьяат Халх голын байлдааны эрэлхэг байлдагч, гарамгай тагнуулч Цэндийн Олзвойд БНМАУ-ын баатар цол олгожээ.*



## ХЯЗГААРЫН ЦЭРГИЙН ЗОРИГТ ДАРГА БАДРАНГУЙ ЭХ ОРОНЧООРОО ГАВЬЯАТ ҮЙЛСЭЭ МӨНХӨЛСӨН НЭХИЙТ БААТРЫН БААТАРЛАЛЫН ТУХАЙ ДАВТАЛТТАЙ ШҮЛЭГЛЭЛ

Гучин удаа байлдаанд явна гэдэг  
Санахад тун таггүй хэрэг ч  
Гучуулд нь баатарлан ялна гэдэг  
Бодоход мөн яггүй ажил ч  
Гучин удаа байлдаж явсан  
Байлдагч байна. Багачууд аа!  
Гучуулд нь баатарлаж ялсан  
Баатар байна. Хүүхдүүд ээ!  
Тэр баатар  
Гучин удаа байлдаанд явахдаа  
Тэвдэж, сандарсан ч үгүй  
Тээршээж, шантарсан ч үгүй  
Тэр баатар  
Гучин удаа баатарлаж ялахдаа  
Онгорч сагсуурсан ч үгүй  
Омогшиж, гайхуулсан ч үгүй  
Эх орноо зүрхнээсээ илүү хайрлаж  
Эрхт олноо тархинаасаа илүү хамгаалж  
Эх орныхоо атга шороог ч  
Дайсанд алдахгүй гэж тэмцэж явсан  
Эх орныхоо балга усыг ч  
Дайсанд амсуулахгүй гэж тулж ялсан  
Энийг чинь эх оронч үйлс гэхгүй юм бол  
Өөр юуг эх оронч үйлс гэх юм бэ?  
Энэ хүнийг эх оронч гэхгүй юм бол  
Өөр хэнийг эх оронч гэх юм бэ?



Долоо дахин дайсны ард нэвтэрнэ гэдэг  
Санахад тун таггүй хэрэг ч  
Долуулд нь баригдалгүй ирнэ гэдэг

Бодоход мөн яггүй ажил ч  
Долоо дахин нэвтэрч чадсан  
Тагнуулч байна. Багачууд аа!  
Долуулд нь олзтой ирсэн  
Баатар байна. Хүүхдүүд ээ!  
Тэр баатар  
Долоо дахин тагнуулд явахдаа  
Хулчийж айсан ч үгүй  
Хургаж, хоргосон ч үгүй  
Тэр баатар  
Долоо дахин нэвтэрч орохдоо  
Бээвийж бэрхшээсэн ч үгүй  
Бээцийж зүрхшээсэн ч үгүй  
Эх орноо зүрхнээсээ илүү хайрлаж  
Эрхт олноо тархинаасаа илүү хамгаалж  
Эх орныхоо даалгаврыг  
Эндэлгүй биелүүлж, тэмцэж явсан.  
Эрхт олныхоо итгэлийг  
Алдалгүй хадгалж тулж ялсан  
Энийг чинь зориг гэхгүй юм бол  
Өөр юуг зориг гэх юм бэ  
Энэ хүнийг зоригтон гэхгүй юм бол  
Өөр хэнийг зоригтон гэх юм бэ  
Хагас мянган дайсанд бүслэгдэнэ гэдэг  
Санахад тун таггүй хэрэг ч  
Хагас мянгын бүслэлтийг сэтэлнэ гэдэг  
Бодоход мөн яггүй ажил ч  
Хагас мянгын бүслэлтийг сэтлээд гарсан  
Дарга байна Багачууд аа!  
Хагас мянгуулыг нь ниргээд ялсан  
Баатар байна. Хүүхдүүд ээ!  
Эх орноо зүрхнээсээ илүү хайрлаж  
Эрхт олноо тархинаасаа илүү хамгаалж  
Эх орныхоо төлөө л бол  
Хөлсөө хайрлахгүй зүтгэж явсан  
Эх орныхоо төлөө л бол  
Цусаа харамлалгүй мэтгэж ялсан

Энийг чинь баатарлал гэхгүй юм бол  
Өөр юуг баатарлал гэх юм бэ?  
Энэ хүнийг баатар гэхгүй юм бол  
Өөр хэнийг баатар гэх юм бэ?

*Ард түмнийхээ энх хөдөлмөр, жаргалант амьдралын төлөө төрөлх  
нутгийнхаа торгон хилийг нүд цавчилгүй сахин хамгаалж  
халдаж ирсэн дайсанд хатуу цохилт өгч, эх орныхоо өмнө  
эрэмгий гавьяа байгуулсан Алтайн хязгаарын домогт эр,  
Одоогийн Булган аймгийн Сэлэнгэ сумын харьяат Жадамбын  
Нэхийтэд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1962  
оны 7 дугаар сарын 13-ны өдрийн 138 дугаар зарлигаар БНМАУ-  
ын баатар цол олгожээ.*

## ОЛОН ДАЙСАНТАЙ ЦӨӨХҮҮЛЭЭ ТУЛАЛДАЖ ОНЦ ГАВЬЯА БАЙГУУЛСАН ГЭЛЭГБААТАР УДИРДАГЧТАЙ АРВАН ЦЭРГИЙН ТУХАЙ ДУУЛЬ МАЯГИЙН ШҮЛЭГЛЭЛ

Энэ шүлгийг та нар уншаад  
Эргэлзэн гайхахын хэрэггүй ээ!  
Үнэн бол уу? худал бол уу? гэж  
Үймэрч бодохын ашиггүй ээ!  
Уран зохиолч өөрийн бүтээлээ  
Уншигч олонд өргөн барихдаа  
Амьдралын үнэн, гагцхүү үнэнийг  
Алдаршуулан дуулахыг зорьдог юм.  
Хуудас цаас өмнө бэлд!  
Хуваах үйлдэл та нар бод!  
Аравт мянгатыг тэнцүү хүртээ!  
Алдалгүй зөв хариуг гарга!

■

Дайны гал дүрэлзсээр л....  
Дарийн утаа маналзсаар л...  
Хурдан сум зөрөлцсөөр л...  
Хурмастын мөндөр шиг асгарсаар л...  
Эзэрхэг дайсны мянган цэрэг  
Эгнэн хошуурч давшиж эхэллээ.  
Хороо цэрэг маань хотгороор мөлхөж  
Хожоотой байр эзлэх боллоо.  
Хороо цэргийг хотгороор мөлхөж  
Хожоотой байр эзлэн эзэлтэл  
Хомхой дайсны сөрөх давшилтыг  
Хорьж саатуулах хэрэгтэй байлаа.  
Алдар хүндтэй энэ үүрэг  
Аймшиггүй зоригт Гэлэгбаатарт ноогдов  
Арвуулхнаа тэд мянгын өөдөөс  
Арслан барс мэт тулалдаж гарав.  
Арвуулхнаа тэд мянгын өөдөөс

Амсхийх завгүй галлаж байлаа.  
Галлах бүрдээ галзуу дайсныг  
Ган илдтэй нь устгасаар байлаа.  
Тэгэвч дайснууд давшсаар байлаа.  
Тээр тэндээс дөхсөөр байлаа.  
Гэлэг баатарчууд галласаар байна.  
Гэдрэг ухралгүй тулалдсаар байлаа.  
Гэлэгбаатар нөхдөдөө тушаалаа:  
Гэдрэг ухарч явсан ч болохгүй  
Ганц ч сумаа газарт гээлгүй  
Гавал цээжийг нь өрөмд... гэлээ  
Их бууны нь амнаас гарсан  
Исгэрэн шуугих ган сумнууд  
Дараа дараагаар залган очиж  
Дайсныг цөм цохисоор байлаа  
Дөтлөөд ирсэн мянган цэргийг  
Дөрвөн цаг хорьж чадлаа.  
Эцэст нь тэд хүчинд нь автан  
Эрэлхэг баатарлагаар нас нөхөцлөө.

*1939 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Халх голын орчимд дайсны үлэмж давуу хүчний эсрэг шантаршгүй зоригтой байлдаж эрэлхэг баатарлагаар амь үрэгдсэн Хөвсгөл аймгийн Ханх сумын харьяат МАХН-ын гишүүн Лувсандоржийн Гэлэгбаатарт БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Халх голын байлдааны ялалтын 25 жилийн ойг тохиолдуулан БНМАУ-ын баатар цол нэхэн шагнажээ.*

## ЭРЭЛХЭГ ХИЛЧИН, ОНЦ БУУДАГЧ, ЭВЛЭЛИЙН ГИШҮҮН, ДАМБА ЭЦСИЙН СУМЫГ ӨӨРТӨӨ ЗОРИУЛСАН ТУХАЙ ШҮЛЭГЛЭЛ

Хорин настнууд  
Армид дайчлагдах тэр үеэр  
Хорлоогийн Дамба  
Арван естэй байсан юм.  
Таны нас  
Арай болоогүй байна гээд  
Татлагын комисс  
Бүртгэж авахгүй байсан юм.  
Дамбын сэтгэл  
Тэгэхэд нэг гуньсан юм.  
Дарга нарыг нь  
Тэвдүүлж баахан гуйсан юм.  
Хий настайгаа  
Хорьтой ч гэж хэлж үзсэн юм.  
Хэчнээн ядавч  
Аргалж ер болоогүй юм.  
Цэнэгт буу үүрэх сэн гэж  
Санадаг байсан юм тэр  
Цэцэн буудагч болох сон гэж  
Боддог байсан юм тэр.  
Цэрэг болж алхах сан гэж  
Хүсдэг байсан юм тэр  
Цээжин дотроо өчнөөн бодол  
Хадгалж явсан юм тэр  
Өмнөдэлгэр сумын төвөөс  
Шижгэр залуус мордоход  
Өмнөө тугаа намируулаад  
Шинэ цэрэг хөдлөхөд  
Агсан морио унаад  
Дамба тэднийг дагасан юм.  
Аймгийн төв дээр очоод  
Дарга нараас дахин гуйсан юм.  
Зүтгэсээр байгаад Дамба

Ардын цэрэгт мордсон юм.  
Мэтгэсээр байгаад дараа нь  
Торгон хил дээр очсон юм.  
Хилийн харуулд очоод  
Хичээлдээ онц сурсан юм.  
Хичээлдээ онц сураад  
Мэргэн буудагч болсон юм.  
Баруун хязгаарын байдал  
Түгшүүртэй гэдгийг сонсоод  
Бас л тийшээ очъё гэж  
Саналаа тэр өгсөн юм.  
Баян-Өлгийд шилжиж  
Бат хилээ манасан юм.  
Байлдаанд тэнд орж  
Баатар гавьяа байгуулсан юм.



Дамба, гурван нөхөртэйгөө  
Дархан хилээ манаж байв.  
Давхраат нүдээ цавчилгүй  
Дайсны аюулыг анаж байв.  
Ханагар сайхан орны минь  
Халдашгүй дархан хилийг  
Хасгийн зуун дээрэмчин  
Харайгаад давж иржээ.  
Байр сонгож отохоос  
Ондоо аргагүй боллоо.  
Байлдаж тэдэнтэй тулахаас  
Өөр замгүй байлаа.  
Буун дуу гарлаа.  
Буудалцлаа.  
Бум түмэн сум  
Хоёр тийшээ зөрөлдлөө.  
Байлдлаа.  
Байлдаан эхэллээ.  
Дөрөвхөн хүн  
Зуун хүний өөдөөс гарамгайлж

Дөрөвхөн буу  
Зуун бууны өмнөөс галлаж  
Туллаа  
Тулалдаан ширүүслээ  
Хэн хэнийхээ талаас  
Хороолоо  
Хорлолоо  
Хээрийн зөөлөн хөрсөнд  
Хэн хэнийх нь цус  
Урслаа  
Ууслаа  
Дайтлаа  
Дайн улам ширүүслээ  
Хортны суманд  
Нөхөд нь өртөж  
Гүйцлээ.  
Дууслаа.  
Хорлоогийн Дамба  
Гав ганцаар  
Үлдлээ  
Хоцорлоо.  
Дамба руу  
Дайснууд  
Дайрлаа  
Давшиллаа.  
Даанч олуулаа байлаа  
Давж баршгүй байлаа  
Унагаж гүйцэшгүй байлаа  
Улангассан түрж байлаа.  
Улайран дөхөж байлаа.  
Дамба  
Шантарсангүй.  
Сандарсангүй  
Ухарсангүй, харин  
Урагшиллаа.  
Дамба  
Шархадлаа



Дахин шархадлаа  
Дахин бас шархадлаа  
Ахин бас шархадлаа  
Бүгд долоо шархадлаа  
Бүтэн биегүй боллоо.  
Тэгэвч Дамба галласаар  
Тэрсүүд дайсныг газардуулсаар  
Онхолдуулсаар, устгасаар  
Ойчуулсаар, хэвтүүлсээр...  
Эрэлхэг хилчний бие  
Эндлээ  
Эвлэлийн гишүүний батлахаа  
Эвдэж устгаж буллаа.  
Хасгууд, дайраад ирлээ.  
Хашхиран, давшаад ирлээ.  
Заавал түүнийг амьд барина гэж  
Занасаар, зүхсээр шавж ирлээ.  
Дайснууд:  
Галзуурсан юм шиг овоорч бүрхлээ  
Дамба:  
Ганц сумаа өөртөө зориуллаа.  
Энэ нь учиртай байлаа.  
Ингэх нь утгатай байлаа  
Харгисын гарт амьд баригдах нь  
Харийн нутагт хүргэгдэн очих нь  
Мөч, махаа зулгаалган  
Тамлагдан зовоохын нэр  
Мөрдөн байцаалтад тулгагдан  
Тарчлан шаналахын нэр  
Эх оронч хүнд тохиолдошгүй  
Эрэлхэг зоригтонд байшгүй  
Ард түмэндээ буруутай хэрэг  
Ач үрстээ зэмтэй хэрэг гэж  
Баттай бодоод ноттой шийдээд  
Баатрын ёсоор нөхөцсөн нь тэр ээ!  
Амьд барьж чадаагүйдээ  
Харгисууд харамслаа

Аргаа барж ядсандаа  
Хасгууд харууслаа.  
Дайсны дарга гэнэтхэн  
Цэргүүдээ цуглууллаа.  
Давчидсан өндөр дуугаар  
Даруй ингэж зандалаа.  
— Нөхөд!.. цэргүүд ээ!..  
Нөмөрсөн хувцасны голууд аа!  
Мал шиг тэнэгүүд ээ!..  
Мануухай болсон гозгорууд аа!  
Та нар чинь  
Зуугуулаа байгаагүй бил үү?  
Тал хувиа  
Зууртаа орхисноо мэдэв үү?  
Цэрэг хүний зориг  
Ямар байх ёстойг  
Цэхэр ногоон нүднүүдээрээ  
Харцгаав уу? та нар?  
Байлдагч хүний хатуужил  
Ямар байх ёстойг  
Баримтын дээд үүнээс  
Үзэцгээв үү? та нар  
Эх орондоо үнэнч  
Монгол цэргийн зоригийг  
Эргүү тэнэг та нар  
Шингээж чадах уу? үгүй юу?  
Эцсээ хүртэл тулалддаг  
Монгол эрийн золбоог  
Энэнээс хойш та нар  
Тунгааж авах уу? үгүй юу?  
Зоригт эрийн цуснаас  
Цөм та нар амсацгаа!  
Зориг зүрх чинь нэмэгдэж  
Золбоо хийморь чинь сэргэнэ.  
Амс! Одоо амс  
Алгандаа хийгээд амс  
Аймшиггүй чин зоригтой

Үүн шиг баатар болцгоо! гэв.

*Нам засгийнхаа даалгаврыг гарамгай биелүүлж, эх орныхоо ариун дархан хил хязгаарыг эрэлхэг баатарлагаар хамгаалан тэмцэж амь үрэгдсэн Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын харьяат МХЗЭ-ийн гишүүн Хорлоогийн Дамбад БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1961 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 270 дугаар зарлигаар БНМАУ-ын баатар цол нэхэн шагнажээ.*

## ЭРЭМГИЙ ЗОРИГТ, ЭРЭЛХЭГ ХОЛБООЧИН ЖАНЧИВ, ДАЙСНЫ СУМАН ДУНДУУР СӨРӨН МӨЛХӨЖ ТАСАРСАН ХОЛБООГ ЗАЛГАСАН ТУХАЙ ШҮЛЭГЛЭЛ

Манай улаан цэргүүд  
Мятралгүй дайтсаар  
Шантралгүй давшсаар  
Жанжин штабынхаа тушаалыг  
Тухай бүрд нь биелүүлсээр  
Жанчхүүгийн даваанд  
Тулж очоод байлаа.  
Тэнд дайсны хүч их  
Тэсрэх бөмбөг  
Исгэрэх сум зогсоо зайгүй  
Өөд уруугүй  
Өндийх завгүй  
Суман мөндөр асгаж  
Шуурган гал нээж байв.  
Манай холбоог дайснууд  
Магад хорлон тасалжээ,  
Анги, хороодыг  
Ярилцаж чадахгүй болгожээ.  
Ар тийшээ ч  
Харилцаж болохгүй хоригложээ.  
Дайны хүнд үе  
Тулж ирлээ.  
Дайсны их хүч  
Бүсэлж авлаа.  
Ийм үед чухам л  
Харилцаа-холбоо чухал  
Их ялалтад хүрэхийн  
Хамаг найдвар түүнд  
Ингэхлээр одоо яах вэ?  
Дарга жаахан бодлоо.  
Итгэлт сайн холбоочноо  
Даруй түргэн дуудлаа.



Даалгасан ёсоор Жанчив  
Дамартай утсаа хөвсөөр  
Давааны ар дахь судгаар  
Давшин гулсаж эхэллээ.  
Дайсан түүнийг хараад  
Даанч ширүүн галлаж  
Дал мөрийг нь шархдуулж  
Дахин бас шархдууллаа.  
Зоригт холбоочин Жанчив  
Зогсолтгүй цааш мөлхсөөр  
Хувцасныхаа өвдөг тохойг  
Салбаран урагдтал мөлхсөөр  
Хуга буудуулсан гараа  
Санжуулан чирэн мөлхсөөр  
Хүрэн улаан цусаараа  
Зам татуулан мөлхсөөр  
Үхэвч би эх орондоо  
Үнэнч хэвээр үхнэ  
Үхэвч би эх орныхоо  
Үүрэг даалгаврыг биелүүлнэ.  
Үхэвч би энэ холбоог  
Заавал холбож үхнэ  
Үхэвч би энэ утсыг  
Залгаж харилцуулж үхнэ.  
Ганцхан ийм зорилгоор  
Жанчив мөлхөн урагшилж  
Ган болд зоригоороо  
Жанчив хөвчлөн урамшиж  
Холбоо тасарсан газарт  
Хоромхон зуур хүрлээ.  
Хоёр утсыг нь нийлүүлж  
Холбох гаргүйдээ гутарлаа  
Гутарч саатахын хэрэггүй  
Түргэн наадахаа залгаач!  
Гунигт хэцүү хохирол

Манай талд учрах нь  
Гурав дөрвөн талаас  
Дайснууд бүсэлчхээд байна.  
Гучаадхан мөчийн дараа  
Дайрч ирэхээр бэлдчихээд байна.  
Үүрэг өгсөн дарга нь  
Шаардаж байх шиг санагдлаа  
Үй түмэн цэрэг нь  
Шахаж байх шиг бодогдлоо  
Эх орон нь нэлэнхийдээ  
Ширтэж байх шиг үзэгдлээ.  
Эх эцэг нь хүүдээ  
Итгэж байх шиг харагдлаа  
Холбоочин Жанчив ашгүй  
Нарийн ухаан сийллээ.  
Хоёр утасны үзүүрийг  
Ганц гараараа нийлүүллээ,  
Холбож чадахгүй болохоор нь  
Амандаа тэр үмхлээ.  
Хасын цагаан шүдэндээ  
Хачин чанга зуулаа.  
Ардаг дайсан түүнийг  
Дөрөв дэх удаагаа шархдуулж  
Амин тус газарт нь  
Сумаа шигтгэж амжсанаар  
Аймшиггүй түүний зүрхэн  
Цусаа бүлэхээ зогсовч  
Амандаа зуусан хэвээр  
Амь нас нь төгсөвч  
Анги салбарууд хоорондоо  
Саадгүй түргэн харилцаж  
Ар тийшээ холбогдон  
Сааргүй сайн ярилцаж  
Бүлэг хороогоо удирдаж  
Хүч чадлаа зузаалж  
Бүсэлж байсан дайсныг  
Бүгдийг хиар цохилоо.



## МЭРГЭН БУУДАЖ, ТҮРГЭН ДАВШИГЧ ЧИН ЗОРИГТ АЮУШИЙН ТУХАЙ ДУУТАЙ ШҮЛЭГЛЭЛ

Зориг гэгч бол хүний  
Дээд зэргийн чимэг  
Зоригтой байвал хүн  
Юуг ч бүтээж чадна  
Зориг муутай эр  
Мянга дахин үхдэг гэж  
Зон олны маань хэлдэг  
Мэргэн үг бий сэн.



Хүч тэнцвэргүй тулалдаан  
Ид дундаа үргэлжилж  
Хүнийхэн манайхан хоёрын  
Шуурган сумнууд зөрөлдөж

Таг таг таг таг таг  
Таг таг таг таг таг  
Хүнд, хөнгөн пулемётууд  
Хүзүү сунган тачигнана.

Пан...пан...пан...  
Пин... пин... пин...  
Шидсэн гранатууд тэсэрч  
Ширэмний хэлтэрхийнүүд цацагдана.

Ких... ких... ких...  
Ких... ких... ких...  
Винтов буунууд тасхийж  
Пянтаа цайтал пасхийнэ.

Лүн... лүн... лүн...  
Лүг... лүг... лүг...  
Их буунууд нүргэлж



Бүх саадыг нураана.

Дээрээс бөмбөг унаж  
Дэргэдээс мина дэлбэрч  
Шийдвэрлэх тэр тулалдааны  
Ширүүнийг хэлээд яана?

Аюуш давшиж байна  
Ангийнхаа өмнө давшиж явна.  
Аюуш давшиж байна  
Армийнхаа түрүүнд давшиж явна.

Дэлхийд хосгүй хүчирхэг гэж  
Дэмийрч, солиорон гайхуулдаг  
Квантуны «шалгарсан» арми гэгчийн өөдөөс  
Урвагч Дэмчигдонровын  
Улангассан цэргийн урдаас  
Манайхан давшиж байлаа  
Манлайд нь Аюуш давшиж байлаа.  
Магнайнахаа хөлсийг  
Арчилгүй давшиж байлаа.  
Махныхаа шархыг  
Боолгүй давшиж байлаа.

Өөрсдийнхөн рүүгээ шүршиж байгаа  
Өчнөөн төчнөөн галын цэгийг  
Аюуш устгасаар, цөөлсөөр  
Давшиж байлаа.  
Аюуш ахисаар, дөхсөөр  
Дайтаж байлаа.  
Суу зоригоор хэн маань  
Илүү вэ? гэдгээ шалгана!  
Сурсан, мэдсэн бүхнийгээ  
Ид шидийг сорино! гээд

Аюуш давшиж байлаа  
Ангийнхаа өмнө давшиж байлаа.  
Аюуш давшиж байлаа.

Армийнхаа түрүүнд давшиж байлаа.  
Бодоод үзье л дээ хүүхдүүд ээ!  
Бороо шиг асгарсан сумны өөдөөс  
Хад чулуун хүн биш мөртөө.  
Хатуу болд биегүй мөртөө  
Давшина гэдэг амар уу даа үгүй юү?  
Дайтна гэдэг ямар вэ дээ? тэгээд  
Ийм л шүү дээ! багачуудаа!  
Идэр цэрэг, байлдагч эр гэдэг чинь  
Эх орон, биднийгээ хамгаалж  
Ингэж л баатарлаж явлаа шүү дээ!  
Ээ!.. халаг аа... яана?... та минь... ээ  
Эс үзэгд... бүү харагд...  
Эрэлхэг Аюуш шархадчихлаа.  
Эгмээ хуга буудуулчихлаа.

Дайсны бүх буу  
Ганцхан Аюуш дээр ониллоо.  
Дайсны бүх сум  
Ганцхан Аюуш дээр овоорлоо.  
Аюушийг дайсны сум  
Өрөмдөөд л байлаа.  
Аюуш, дайсныг сумаараа  
Өрөмдөөд л байлаа.

Бие биеэ өрөмдөөд л байлаа.  
Өмлөөд л байлаа.  
Биеийг нь сум шөвөгдөөд л байлаа  
Шөрөгдөөд л байлаа.  
Аюушид 11 сум шивлээ  
Ариун биеийг нь 11 сум хавлаа.  
Хортны сум орохдоо  
11 нүхэллээ.  
Хортны сум гарахдаа  
11 нүхэллээ.

Хоёроор тэгээд үржүүлбэл  
Хорин хоёр нүхэллээ.

Тэглээ ч Аюуш үхээгүй  
Тэдний суманд үрэгдээгүй  
Тэмцэж зүтгэж ялж байлаа.  
Тэмцэл нь улам ширүүсэж байлаа.  
Аюуш сумаа дууслаа  
Арван мянган сумаа  
Агаарт биш, газарт биш  
Атаатанд, аминд нь шигтгэжээ.

Алагдсан дайсны бууг авлаа  
Ашгүй тэр нь цэнэгтэй байлаа.  
Өөрийнх нь буугаар өөрсдийг нь хяргалаа.  
Өндийж бослоо... босоо үх...лээ...

*Үнэн хэргийн төлөө үхлээс айлгүй тэмцэж алтан амиа алдсан  
Өвөрхангай аймгийн Төгрөг сумын харьяат Лувсанцэрэнгийн  
Аюушид БНМАУ-ын баатар цол олгожээ.*

## АРДЫН ХАЙРТАЙ ХҮҮ АЛАГ МОРЬТОЙ БААТАР, МОНГОЛЫН ЧАПАЕВ ДАНДАРЫН ТУХАЙ ТУУЛЬ МАЯГИЙН ШҮЛЭГЛЭЛ

Эртээ урьд цагт л гэнэ  
Энэ л төрийн үед л гэнэ.  
Хуучин цагийн сүүлд л гэнэ.  
Хувьсгалт засгийн үед л гэнэ  
Хангай говь нь хосолсон  
Ханагар уудам нутагтай  
Халгих ус нь мэлтэлзсэн  
Харз мөрөн голуудтай  
Уулаараа алаглан бэлчсэн  
Тоо томшгүй адуутай  
Ухаагаараа бүрхэн идээшилсэн  
Тоолж баршгүй үхэртэй  
Талаараа нэлдээ тархсан  
Сая живаа хоньтой  
Говиороо дүүрэн багширсан  
Үй түмэн тэмээтэй  
Хадаараа асан тоглосон  
Үймж бужигнасан ямаатай  
Алдарт нутагтаа хайрлагдсан  
Ард олондоо энхрийлэгдсэн  
Давамгай зоригт, гарамгай баатар  
Дандар гэж нэгэн сайн эр байв л гэнэ ээ  
Энэ л сайн эрийн  
Эдэлж унадаг морийг нь хэлбэл  
Тэгш сайхан зоотой  
Тэвхгэр сайхан биетэй  
Цацарсан өтгөн сүүлтэй  
Цацагласан шингэн дэлтэй  
Ган дөрвөн туурайнаас нь  
Гал цахилгаан бадардаг  
Есөн ес наян нэгэн  
Хөлгийн шинж бүрдсэн  
Хөвөн үүлтэй тэнгэрийн

Доохнуур дүүлдэг  
Хөвч модтой уулын  
Дээхнүүр цойлдог  
Жил явах алсыг  
Сар явж хүрдэг  
Сар явах холыг  
Өдөр явж очдог  
Өдөр явах газрыг  
Цаг явж бардаг  
Өндөр алаг морьтой юм санжээ.  
Орон нутагтаа бахдагдсан  
Олон түмэндээ магтагдсан  
Эр зоригт, эрэмгий чадалт  
Энэ л баатрын шинжийг хэлбэл  
Хүн бие нь  
Хүрлээр бүтсэн  
Хүзүү сээр нь  
Гангаар бүтсэн  
Хурдан бууны сумаар  
Оновч даадаггүй  
Хурц сэлмийн ирээр  
Цавчивч тоодоггүй  
Хоёр гарт нь  
Хорин гардийн хүч тэнцсэн  
Хоёр хөлд нь  
Хорин барын хүч хуралдсан  
Нүдэндээ цог хийморьтой  
Нүүрэндээ гал гялбаатай  
Айж сандарна гэхийг мэддэггүй  
Арагшаа ухарна гэхийг мэддэггүй  
Түмэн цэргийнхээ  
Манлайд давхидаг  
Буман цэргийнхээ  
Магнайд довтолдог  
Бууршгүй их хүчтэй  
Буцалтгүй бөх зоригтой  
Хүч ихт баатар

Хүдэр эр байж л гэнэ ээ.  
Хорвоод л нэртэй  
Хотолд л зартай  
Тархиндаа ухаантай  
Ташаандаа сэлэмтэй  
Зүрхт энэ баатрын  
Зүүдэг зэвсгийг нь хэлбэл,  
Орчлонгийн сайн хүдрийг  
Олж хайлуулж цутгасан  
Оросын сайн дархнууд  
Олон давтаж хавтгайлсан  
Агар зандан бариултай  
Алд дэлэм хэмжээтэй  
Хялгас тавихад хяргадаг  
Хад цавчихад эмтэрдэггүй  
Хаа холоос гялалздаг  
Харанхуй шөнө гэрэлтдэг  
Ган болдын сайнаар бүтсэн  
Гайхамшигт эрдэнийн сэлэмтэй юм санжээ.  
Энэ баатар, нэгэн өдөр  
Эх нутаг руугаа халдсан  
Эрдэнэ баялаг руугаа шунасан  
Эрхт олон руугаа довтолсон  
Зүүн зүгийг эзлэнхэн төрсөн  
Зүс нь цагаан ч  
Сэтгэл нь хар  
Дүрс нь хүн ч  
Санаа нь чоно болсон  
Салаалан арзганасан  
Түм буман толгойтой  
Сарвайлдан ярзганасан  
Бум түмэн гартай  
Хамаг амьтны хараал идсэн  
Хатан дэлхийн зүхэл эдэлсэн  
Алах хядахын дон нөхөцсөн  
Авах талахын шунал шүглэсэн  
Араа шүдээ билүүдсэн

Аюулт хар мангас,  
Ёрын муухай орилсоор  
Ёсон бусаар авирласаар  
Ёроолгүй далайн тэртээгээс ирсэн  
Японы самуурайнуудыг дарахаар  
Хий салхинд гүйцэгдэшгүй  
Хилэн алаг морио барьж  
Хуй салхинд гүйцэгдэшгүй  
Хурдан алаг хөлгөө унаж  
Хөх тэнгэрийг хэлбэлзүүлэн  
Хөрст газрыг хөлбөлщүүлэн  
Уул уулыг найгатал  
Ус усыг цалгитал  
Уудам талыг хотолзтол  
Ухаа толгодыг навталзтал  
Түмэн цэргийнхээ  
Манлайд нь гаран довтолж  
Буман цэргийнхээ  
Магнайд нь яван давшиж  
Орчлонгийн сайн хүдрийг  
Олж хайлуулж нягтруулсан  
Оросын сайн дархнууд  
Олон давтаж хавтгайлсан  
Агар зандан бариултай  
Алд дэлэм хэмжээтэй  
Хаа холоос гялалздаг  
Харанхуй шөнө гэрэлтдэг  
Сэнс мэт эргэлддэг  
Сэлэм юугаан далайгаад  
Өөдгүй тэр дайснуудын  
Өмнөөс нь угтан давхихад нь  
Дэрвэсэн нөмрөгийнх нь салхинд  
Дэнжийн шороо босож л гэнэ.  
Хашхирсан урианых нь дуунд  
Хатан дэлхий чичирхийлж л гэнэ.  
Шороон түмэн дайсан  
Шоргоолж адил үймж л гэнэ.

Орох гарах газраа эрэн  
Оготно адил гүйлдэж л гэнэ.  
Атаатан дайсан түм түмээрээ  
Алаг мориных нь хөлд сүйрч л гэнэ.  
Араатан самуурай бум бумаараа  
Алтан сэлмийнх нь ирэнд үйрч л гэнэ.  
Дайснаа дараад  
Дархан цолоо олоод  
Өштнөө ялаад  
Өргөн цолоо олоод  
Орон нутагтаа буцаж л гэнэ.  
Олон түмэндээ хүндлэгдэж л гэнэ.  
Аймшиггүй чин зоригтон  
Алаг морьт баатар минь  
Аюулын замаас гаргасан  
Аврал ихтэй хүү минь гэж  
Эх нутаг нь тосож л гэнэ.  
Эгэл олон нь угтаж л гэнэ.  
Төр засаг нь хүндэлж л гэнэ.  
Түмэн олон нь хүрээлж л гэнэ.  
Ардын баатар цол хүртээж л гэнэ  
Алтан соёмбо тэмдэг зүүж л гэнэ.



## ДАМПИЛ АВАРГА, ДАЙСНЫ ТОМ ДАРГЫГ ТУЛАЛДААНЫ ТАЛБАРТ АМЛАН АВЧ ТАМЛАН ХАЯЖ БАРИЛДСАН ТУХАЙ ЦОЛЛОЛТ ШҮЛЭГ

Хүүхдүүд ээ!

Баатар баатрын баатарлалын тухай  
Бадаг бадгаар шүлэг бичихэд  
Байгуулсан ялалт, гавьяаных нь тухай  
Багачууд та нартаа бахархаж ярихад  
Зориг-зүрх нэмэгдээд ч байх шиг  
Золбоо-хийморь чимэгдээд ч байх шиг  
Хүч чадал зангираад ч байх шиг  
Хүдэр булчин чангараад ч байх шиг  
Эдэнтэй адил байлдсан ч юм шиг  
Эзэрхэг дайсантай тулсан ч юм шиг  
Өөрөө баатар болчихсон ч юм шиг  
Нэг л аятайхан санагдаад байх юм.

Багачууд аа!

Баатар баатрын баатарлалын тухай  
Бадаг бадгаар шүлэг уншихад  
Байгуулсан ялалт, гавьяаных нь тухай  
Багачууд та нар бахархан сонсоод,  
Зориг зүрх чинь нэмэгдэж байна уу?  
Золбоо хийморь чинь чимэгдэж байна уу  
Хүч чадал чинь зангирч байна уу?  
Хүдэр булчин чинь чангарч байна уу?  
Эдэнтэй адил  
Байлдсан юм шиг санагдана уу?  
Эзэрхэг дайсантай  
Дайтсан юм шиг бодогдоно уу?  
Өөрт чинь  
Ийм баатар болох сон гэж  
Хүсэгдэнэ үү?  
Өөрсдөд чинь ер нь  
Ямар байна даа  
Хүүхдүүд ээ!



За цаана чинь  
Байлдаан эхэллээ  
Заналт дайсны өмнөөс  
Манайхан давшлаа  
Одоо хэн нь яаж  
Баатарлаж ялахыг  
Олуулаа сайхан  
Хараад байя!  
Тасгийн дарга Сэдбазар  
Тасхийсэн өндөр дуугаар  
Дампил пулемётчин давшаад...  
Дайсны галыг устгаад!.. гэв.  
Тушаал бол ерөөсөө  
Тушаал байдаг ёстой  
Тулгагдсан хүндээ бол  
Хууль байдаг учиртай  
Дампил, давшиж эхэллээ.  
Давшингуутаа шүршиж эхэллээ.  
Шүршингүүтээ устгаж эхэллээ.  
Устгангуутаа давшсаар байлаа.  
Дайсны талаас галлаж байгаа  
Далд нуувчийн галын цэгүүдийг  
Цөөлсөөр сөнөөсөөр давшиж байлаа  
Цөмөөрөө дуугүй, чимээгүй боллоо.  
Санаа нь амраад Дампил  
Салаагаа давшуулах гэтэл  
Хажуугийн нүхнээс дайсны пулемёт  
Хачин ширүүн галладаг байгаа ...  
Элгэн биеэрээ гулсаж  
Эрүүгээ газраар шүргүүлэн  
Аймшиггүй зоригт Дампил  
Алгуурхан түүнд ойртлоо.  
Дампил бодлоо  
Дайсныг баръя гэж  
Дампил шийдлээ

Дайсантай барилдъя гэж  
Тэгээд улам ойртлоо  
Тэгэхэд нь ингэж санагджээ.  
"Зүүн талын засуул" сонсоорой! ...  
Бүгд Найрамдах  
Монгол Ард Улсын  
Архангай аймгийн  
Цэнхэр сумын харьяат  
Даяар дурсах  
Далай даян  
Дархан аварга  
Олныг баясуулагч  
Түмнийг цэнгүүлэгч  
Үнэн хүчит  
Өрнөн дэлгэрэх  
Харьшгүй зоригтой  
Бууршгүй хүчтэй  
Баруун талынхаа гарт  
Бар арслангийн тэнхээтэй  
Зүүн талынхаа гарт  
Баавгай зааны чадалтай  
Дархан аварга Дампил аа...»  
Энэ тулалдааны талбарт  
Эзэрхэг самуурай японы  
Өөрсөд рүүгээ галлаж байгаа  
Өндөр тушаалтай даргыг чинь  
Амлан авч, хүчийг үзье ... гэв ээ... ? гэж  
Эх орон нь  
Нам засаг нь  
Цол гуншин дуудаж  
Цог хийморь сэргээж  
Сая хүний хос нүд  
Салахгүй ширтэх шиг бодогджээ.  
Дампил ухасхийн дайрлаа.  
Дайсан угтан бослоо.  
Барилцаж авлаа.  
Багалзуур хоолойгоо шахалцлаа

Дээр дороо оролцлоо.  
Дээл хувцсаа уралцлаа  
Дэлхийн шороог тээрэмдлээ  
Дайсан тун тэнхээтэй байлаа  
Даагдаж өгөхгүй хүнд байлаа.  
Дампилтэй хүч тэнцүү санагдавч  
Дарж унах гээд тэвдүүлж байлаа.  
Дампил байдаг мэхээ  
Дараа дараагаар хийлээ  
Аймаг сумын баяр наадмаар  
Амлан авдаг монгол бөхөөс  
Арай ондоо, адайр зантай  
Араншин муутай «бөх» байлаа.  
Бүтэх бүтэхгүй аргаар  
Элдэв мэх ч хийж байв.  
Бүр сүүлд нь танагаа бараад  
Энд тэндээс нь хазаж байв.  
Дампил...  
Суун тусангуутаа  
Өмсөөд авсан чинь болсонгүй  
Сугадаж авангуутаа  
Тонгороод орхисон чинь барсангүй  
Суйлж оронгуутаа  
Өргөөд үзсэн чинь даасангүй  
Дайрч ухасхийнгүүт  
Хавсраадахсан чинь бүтсэнгүй  
Давхар ачингуут  
Хажуулдаадахсан чинь хөдөлсөнгүй  
Дагуулж барингуут  
Гуядчихсан чинь дийлсэнгүй  
Дэгээ ороонгуут  
Эргэсэн чинь болсонгүй  
Дэгдүүлж байгаад  
Дугтарсан чинь унасангүй  
Болохоо байхаар нь Дампил  
Бодогдсон ганц мэхээ гаргаж  
Сэгсэрч байгаад хийн дээр нь

Сээрэн дунгуй хатгуулж орхив.  
Дайсныг ингэж дийлж  
Давамгай чадлаа илтгэв.

*Эх орныхоо даалгаврыг гарамгай биелүүлж гавьяа байгуулсан  
Архангай аймгийн Цэнхэр сумын харьяат Сангийн Дампилд  
БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 9 дүгээр сарын  
26-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор БНМАУ-ын баатар цол  
шагнажээ.*

**ХАЛУУН ЭХ ОРОНЧ ХАТАН ЗОРИГТ, МИНОМЁТЧИН  
ДАНЗАНВАНЧИГ ӨӨРИЙНХӨӨ ЧИН ЗОРИГООР НӨХДИЙГӨӨ  
МӨН ЗОРИГЖУУЛСАН ТУХАЙ ШҮЛЭГЛЭЛ**

Тэр үе  
1945 он  
Тэр өдөр  
8 дугаар сарын 19-н  
Ухарч буцалгүй чив чигээрээ  
Уухайлан дайрах манай цэрэг  
Алдарт Хянганд дайсны хориглосон  
Асар том бэхлэлтийг сэтэлж  
Алхам бүр улам  
Цаашилсаар байлаа  
Араатан дайсныг салам  
Цохисоор байлаа  
Зарим нь ухран зугтаж  
Хойшилсоор байлаа  
Зар түүхтэй ялалт маань  
Наашилсаар байлаа.  
Тэд одоо давшиж л байг  
Ухрахыг ямар мэдэх юм биш  
Тэрсүүд дайсныг дайрч л байг  
Устгахыг эс чадах юм биш  
Тэрхэн хооронд самбаачилж  
Тэмдэглэлийн дэвтрээ сөхье!  
Нэгэн сонин үйл явдлыг  
Нэмэр хачиргүй ярья



Ноднин намар би  
Хөдөө явж байлаа  
Ногоо тариа хураалтын  
Ид ажил байлаа  
Хотын нэгэн сургуулийн

Хөдөлмөр зусланд очлоо  
Хоёр зуугаад хүүхэдтэй  
Хөгжилтэй сайхан уулзлаа.  
Тэнэгэр сайхан талбайдаа  
Олон хүүхэд яралзаж  
Тэр намрын ургацын  
Арвиныг хэлэх аргагүй  
Өргөн магнай, намхан хамар дээгүүр нь  
Өлбөн сувд шиг хөлс бурзайн бөнжгөнөж  
Өмссөн хувцас нь  
Өнгө ялгаран алаглаад  
Өргөн талын цэцэгэрхүү  
Хэчнээн гоёхон байсан гээ.  
Тогоон чинээ зантгар, зантгар,  
Байцайнууд хураагаад л  
Толгойн чинээ урт урт  
Луувангууд сугалаад л  
Толгойн хэртэй мундаг мундаг  
Манжингууд шуудайлаад л  
Тоглоомын бөмбөг шиг том том  
Төмснүүд савлаад л  
Байгаа хүүхэд цөмөөрөө  
Тэнд ажиллаж байхад  
Баяр баясгалант хөдөлмөртөө  
Тэмцэж зүтгэж явахад  
Байрандаа хоёр хүүхэд л  
Сугаран үлдэж хоцроод  
Бага өчүүхэн шалтгаар  
Бааш зохиож аргалаад  
Олон төрлийн ногоотой  
Сайхан хоол идэх сэн гэж  
Орондоо хэвтэж санаашраад  
Амаа хий л тамшаалж  
Хүний хойно, морины цаана суусан  
Хүүхэд хоёрыг тэнд л би үзлээ.



Байз! миномёт нүргэлэн  
Дуугарч байна сонсооч!  
Байц хориглолтыг нураан  
Дуулдаж байна чагнаач  
Байзная!.. тэмдэглэлээ  
Зав гарахаар үргэлжлүүлье.  
Байлдааны явцыг  
Цөм одоо ажиглая.  
Данзанваанчигийн  
Миномётын мэргэн сумнууд  
Дайсны галын  
Цэг байрыг онож байлаа.  
Оносон даруй  
Утаа манан огторгуй хатган  
Онуулсан буутнууд  
Тэнгэр харан тэрийж байлаа.  
Ахлагч Дүүдэйн салааныхан  
Араатны өөдөөс урагшилж байна.  
Дайчин алдарт салааны түрүүнд  
Данзанваанчиг урагшилж байна.  
Данзанванчиг минь урагшаа урагшаа  
Давших газар өмнө чинь байна  
Ар талд чинь эх орон  
Ард түмэн, энхрий үрс  
Тэр бүхнээ хамгаал!  
Тэрсүүд дайснаас өмгөөл! гэж  
Данзанваанчиг хэнээр ч шаардуулалгүй  
Давын өмнө өөртөө тушаагаад  
Хөмсгөө нум шиг зангидан  
Хөмхийгөө хөхөртөл зуун  
Хөлөөрөө биш  
Элгээрээ урагшилж байна.

■

Тэгээд би хоёр хүүхэдтэй  
Тэнд уулзаж ярилцлаа л даа.  
Өвдөө юу? хавдаа юу? гээд л



Өчнөөн юм асуулаа л даа  
Хөөрхий минь тэр хоёр  
Эцсийн үнэнээ хэлчихлээ шүү  
Хөх инээд минь хүрээд л  
Элэг хөшчих шахлаа шүү  
Тэгсэн чинь ийм учиртай санж  
Түүнийг хэлэхэд нууц биш юм  
Энд нэрийг нь бичихээ байя.  
Эхний үсэгт нь л эгшгийг нь өгье!  
«Ха...» нь ногоо хураахдаа  
Халгайд шилбээ түлчхэж гэнэ ээ.  
«Га...» нь талх хуваахдаа  
Гараа яльгүй эсгэчхэж гэнэ,  
Өвдсөн гэдэг жигтэйхэн гэнэ  
Хавдсан гэдэг хачин гэнэ.  
Өндийж босож ч болдоггүй гэнэ.  
Өнгөрлөө л гэж бодсон юм байх



Данзанваанчиг шархаджээ,  
Дараа дараагаар шархаджээ.  
Хөлөө халгайд түлээд  
Шархадсан юм биш шүү дээ  
Хөнөөлт дайсны  
Бөмбөгний ширмэнд  
Хуга цохиулчихжээ.  
Тэгэвч хөлөө чирсээр  
Урагшаа давшиж байна.  
Гараа хутгаар эсгээд  
Шархадсан юм биш шүү дээ.  
Галзуу самуурайн  
Пулемётын суманд  
Тас авхуулчихлаа  
Тэгэвч гараа санжуулсаар  
Урагшаа давшиж байна.  
Ууц, нуруу нь бас шархадлаа  
Улаан цус нь хувцсыг нь нэвчлээ.

Тэгэхдээ хутгаар эсгэсэн шиг  
Дусал дуслаар биш шүү дээ  
Хувингаар асгасан шиг л  
Бөөн бөөнөөр урсаж байлаа.  
Данзанваанчиг бүр ч зоригжлоо  
Дайны талбарт улам ч золбоожлоо  
Туслах нөхөр нь "та буц" гэлээ.  
«Тулалдана» гээд тас зөрөөд давшлаа  
Даанч ... тэнхэлгүй боллоо ... уналаа  
Давш! гэж нөхөртөө эрс тушаалаа  
— Битгий намайг сахь!.. давш!  
— Би учраа олно! Яв!... Давш!  
— Асгасан цусны минь орыг ав!... Давш!  
— Амьд дээр минь өшөөг ав!... Давш.  
Данзанваанчигийг амьдаар барихаар  
Дайсны цэрэг муур шиг гэтлээ  
Сонор соргогоор түүнийг мэдээд  
Солгой гараараа буудан тонилголоо.



«Ха ...» «Га ...» хоёр маань  
Хамтын хөдөлмөрийн талбарт  
Улаан лууван, байцаа, төмстэй  
Удтал тулалдаж байлдаж яваад  
«Айхавтар хүнд шархдаад»  
«Ар талд» хоцорсон гэж  
Хамт байсан жаалууд нь  
Хатуу чанга даапаалж  
Ханыхаа сонины хуудсанд нь  
Хачин инээдтэй зурчихсан байж билээ...

*Эх орныхоо төлөө халуун амь бүлээн цусаа үл хайрлан баатарлагаар  
тулалдсан Дорноговь аймгийн Дэлгэр хэт сумын харьяат Дашийн  
Данзанванчигийг БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945  
оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор БНМАУ-  
ын баатар цолоор шагнасан байна.*

## БАРУУН ХЯЗГААРТ БАЙЛДАЖ, БАЙТАГ БОГДОД БААТАРЛАСАН АЙМШИГГҮЙ ЧИН ЗОРИГТ ГУРВАН БААТРЫН ТУХАЙ ЭНЭ НОМЫН ЭЦСИЙН ШҮЛЭГ

Энэ номынхоо эцсийн шүлгийг  
Уншихын өмнө  
Эрхэм дүү нар минь номоо хамхиж  
Түр завсарлана уу?  
Чилж ядарсан бол хэсэг зуур  
Алжаалыг тайлж  
Чи минь тэгээд гараа алдлан  
Гурвантаа сунана уу?  
Ингээд чи цэргийн хүн шиг  
Цэх зогсож  
Эрэлхэг байдлаар цээж түхгэр  
Хараа дээгүүр байж:  
«Өвгөн буурал Байтагийн ууланд  
Өндөр сүрлэг Мэргэний оройд  
Даваадорж, Тэгшээ, Лхагвадорж нар  
Дайсныг дарж, дархан цолоо оллоо.  
Тусгаар тогтносон эх орны минь  
Ариун ялалтыг улам бадрааж  
Түүхт ялалтын дайчин замнал болсон  
Алдарт баатруудаа магтан дуулья...» гэж  
Огцом, огцом үгээр  
Тод тод хэлж  
Оргилуун цовоо дуугаар  
Чанга чанга дуулж  
Байтагийн гурван баатрыг  
Сэтгэл зүрхэндээ төсөөлж  
Бадаглаж бичсэн найргийг минь  
Барж уншаад амарна уу?



Америкийн бүрэн зэвсэгтэй

Гоминданы бүлэг дээрэмчид  
Хэн ч халдашгүй дархан хилийг минь  
Хэдэн удаа зөрчсөн билээ.  
Өндөр босготой манай хилийг  
Өмнөө нутгийн хэн гуай ч гэсэн  
Өнгийх төдий харах ч байтугай  
Өрөөсөн хөлөө ч тавих эрхгүйг  
Тэд өөрснөө мэддэг мөртөө  
Тэгэхээс тэгэх гэсэн юм шиг  
Хорь гучаараа бүлэглэн цөмөрч  
Хоёр зуугаараа бүүрлэн нөмөрч  
Энх хилийн торгон шугамыг тэгнэн  
Элгээрээ харуулдан, амаараа шороо үмхэж  
Нас биеэ манай хилчдэд өргөчхөөд  
Нартаас тэгээд талийдаг байлаа тэд  
Хүний нутгийн зандалчид  
Хүрэн эрэн муур шиг  
Манай нутгийн хилээр  
Мяраан гэтэж мөлхөхдөө  
Ямар зорилготой ирдгийг  
Яриулья гэвэл ийм юм.  
Нэгд:  
Адуу мал дээрэмдье!  
Хоёрт:  
Амьд хэл олзолъё!  
Гуравт:  
Хилийн нутгийг тагная!  
Дөрөвт:  
Хилчдийн чадлыг туршъя.  
Ийм тушаал даргаасаа аваад  
Тийм зорилготой давшаад ирэхэд  
Эднийг яаж угтдаг байлаа!  
Эцэст нь яаж үддэг байлаа!  
Хилчид маань тэгэхэд  
Хилийнхээ шугамыг эзэлж  
Хана, хэрэм болон эгнэж  
Хатуу цайз болон хааж,

Юу ч давшгүй  
Юугаар ч эвдэшгүй  
Хаагуур нь ч нэвтэршгүй  
Хадан хясаа мэт  
Хашаа мэт зогсож байлаа.  
Хятад улс олон жилийн турш  
Хятад хүмүүс олон арван мянгаараа  
Нутгаа тойруулж, хилээ дагуулж  
Нуршгүй бат хэрэм байгуулна гэж  
Шавар, чулуу, туйпуу гурвыг нийлүүлж  
Шавж гагнаж өндөр ханыг босгож  
Дайсан цөмрөхөөс өөрсдийгөө хамгаалж  
Дайн байлдаанаас нутгаа өмгөөлж  
Алдарт цагаан хэрэм гэлцэн  
Алтан дэлхийд зар тарааж  
Амь амьдралаа түүнд даатган  
Амгалан тавтай суудаг байсан нь  
Аль эртний цагт билээ л  
Арилсан, баларсан үед байлаа л ...  
Тэр үед түүнийг нэвтрэх  
Тэнхээтэй дайсан ч байсангүй  
Тэр үед түүнийг эвдлэх  
Техник зэвсэг ч гарсангүй ...  
Одоо бол бүр ондоо байна.  
Орон улсын маань хил хязгаар  
Туйпуу, чулуу, шавраар барьсан  
Туурга хана, хэрэмгүй боловч  
Туйпуу, чулуу, шавраар барьсан  
Туурга-хэрмээс мянгантаа илүү  
Зориг баатарлаг манай хилчдийн  
Зогсоо дайчин хэрэмтэй байна.  
Түүнийг, газар доогуур ч нэвтэршгүй  
Түүнийг тэнгэр дээгүүр ч нэвтэлшгүй  
Тэр хэрмийг бөмбөг тэслээд ч нураашгүй  
Тэр цайзыг ган танкаар ч эвдэлшгүй  
Ийм бат хилчин хэрэмтэй улс чинь  
Илүү ажил гаргаж

Их зардал үрж  
Туйпуу цохиж  
Чулуу тэгшилж  
Шавар зуурч  
Хэрэм барих гээд  
Яах ч юм билээ дээ  
Яршигтай ярвигтай байхгүй юу даа.



Тэр хэрмийн нэгэн хэсэг  
Тэгшээгийн тухай бичье!  
Өстний суманд өртсөн Тэгшээ  
Өрөөсөн хөлөө шөрмөсөөрөө чирч  
Урагшаа давшин, галлан устгаж  
Улангассан дайсныг хяргаж байлаа.  
Тэгтэл сум нь барагдлаа  
Тэрсүүд дайснууд ч ойртон ирлээ  
Тэгшээ, уужуу тайван байж  
Тэнэгэр нутагтайгаа салах ёс хийж  
Амьдаараа та нарт баригдахгүй гэж  
Амандаа тэр чанга хэллээ  
Ариун зэвсгээ ч олзлуулахгүй гэж  
Арынхаа хадыг гуядаж савлаа.  
Энэхэн агшинд Тэгшээ  
Элдвийн зүйл бодлоо.  
Энэ бодол нь түүнд  
Эрэлхэг зориг нэмлээ.  
Эхлээд, эх орноо бодлоо.  
Энүүн шиг сайхан эх орон  
Энэ хорвоод байдаг болов уу гэж  
Элэг зүрхэндээ бодлоо.  
Ард түмнээ бодлоо  
Ариун санаат энэ ард түмнийхээ  
Азтай хүү нь болж төрсөндөө  
Ахуй голоосоо бахархан бодлоо,  
Нам засгаа бодлоо  
Нарт ертөнцөд энэ нам засгийнхаа

Насан туршаа хүртсэн хайрыг нь  
Нар, сарнаас илүүтэйд бодлоо.  
Энэ бүхнийхээ төлөө  
Энэ бүхнээ хамгаалахын төлөө  
Амь насаа үл хайрлах  
Андгай өргөснөө бодлоо.  
Дайснууд хариугүй ирлээ.  
Даруй Тэгшээ амжин завдлаа  
Цэнэгтэй ганц гранатаа зэхлээ  
Цээжин дороо дэлбэлэн нөхөцлөө.



Давшгүй хэрмийн нөгөө хэсэг  
Даваадоржийнх нь тухай бичье.  
Байлдан байлдсаар Даваадорж  
Бас л шархадсан билээ.  
Багшран дайрсан зэрлэг тэдэнд  
Байсан сумаа хүртээсэн билээ.  
Байсан сумаа хүртээсэн боловч  
Дайсан түүнээс олон байлаа  
Дайрч цөмрөөд ороод ирэхэд нь  
Дархан нутагтайгаа салах ёс хийж  
Амьдаараа яасан ч баригдахгүй гэж  
Амандаа тэр чанга хэллээ  
Эвлэлийн батлахаа хаданд нууж  
Эрчлэн дайрах дайсныг хүлээнэ.  
Эх орон надад итгэж байгаа  
Эвлэл нам надад итгэж байгаа  
Эцэг эх надад итгэж байгаа  
Энхрий хүүхдүүд надад итгэж байгаа  
Дайснаас хамгаална гэж итгэж байгаа  
Давуулахгүй, оруулахгүй гэж итгэж байгаа  
Даваадорж ингэж бодоод хэвтэж байлаа  
Давчдаж сандарсан юмгүй хүлээж байлаа  
Баахан дайсан шаваад ирлээ.  
Барьж авахаар сарвалзаад ирлээ.  
Түрж ирсэн дайсан овоороод ирлээ

Түрүүчийн хүний гар биед нь хүрлээ.  
Эх орны төлөө! гэж Даваадорж хашхирлаа  
Эцсийн ганц гранатаа дэлбэллээ.  
Дайрсан дайсан Даваадоржийн хажууд  
Данс дугуйлж, махан овоо боллоо  
Тэгшээ, Даваадорж хоёрын маань  
Тэмцэл ялалт нь ийм л байна  
Газраас дайснууд босоод  
Яаралтай түргэн давшихад  
Гартаа зэвсгээ барьсаар  
Яваад хүрч ирэхэд  
Ганцхан агшин дотор л  
Хамаг бүхнээ шийдэх  
Гал дөлтэй амьдралын  
Хариуцлага эдэнд тулгарсаан  
Энэ бол ерийнхөөс  
Хэцүү шалгалт байсан юм.  
Эцэс хойчид үлдэх  
Сургамж болж өгсөн юм.  
Эрх чөлөөт орны  
Иргэн хүн ийм гэдгийг  
Энгийн малчин ардын  
Төрсөн хүү мөн гэдгийг  
Хадгийн хариунд олддог  
Ерөөлийн сайхан үгээр биш  
Хатуу бэрх тэмцлийн  
Ирэн дээр нь шалгуулахыг  
Халуун хүйтнээс халшралгүй  
Бэлтгэж ирсэн юм тэд  
Хамгийн чухал мөчдөө  
Баталж чадсан юм эд.  
Нэвтэршгүй хэрмийн нөгөө хэсэг  
Лхагвадоржийн тухай бичье.

Дахин дахин улирдаг  
Танил жилүүдийн олонд  
Дархан баатар орныхоо



Тайван хилийг хамгаалж  
Дайсан бүхний өнгөлзлөгийг  
Таньж илрүүлсээр ирсэн  
Давж цөмөрсөн саврыг нь  
Тас цохисоор ялсан  
Цэргийн энэ даргын  
Олон жилийн туршлагад  
Цэвэр үнэнч тэмцлийнх нь  
Ялан дийлсэн баримтад  
Цээжинд багтаж болохооргүй  
Уйтгар ч их байсан юм.  
Цэгнэж юутай ч зүйрлэшгүй  
Баяр ч зөндөө байсан юм.  
Ахмадын байгуулсан гавьяаны  
Алийг нь тоочиж барах вэ?  
Зарим нэгээхнийг дурдаж  
Зах зухаас нь ярья л даа.

1

Зүүн хилийг хамгаалж  
Зүтгэж байлдаж явахдаа  
Аадар ширүүн сумны өөдөөс  
Арслан бар мэт дүүлэн орж  
Гарамгай түргэн хөдөлгөөнтэй  
Гавшгай мэргэн сургуультай  
Гадаадын арван дөрвөн тагнуулчныг  
Гарыг нь өргүүлэн мал шиг тууж  
Ангидаа авчирч тушаагаад  
Ар тийш нь хүргүүлсэн  
Алдар гавьяатай хүн дээ!

2

Зудын шуурганд уруудсан  
Зуугаад мянган адуун сүргийг  
Хил давуулж арилахаас  
Хэл буруутанд алдахаас

Хоргоож, тогтоож  
Хойш нь буцаасан  
Хосгүй гавьяатай эр дээ!

3

Дайны талбарт ганцаараа үлдсэн ч  
Дайсантай, арвуулаа юм шиг тулалдаж  
Давж дийлж баатарлаж явсан  
Дайчин эрэлхэг дарга байлаа.  
Алдарт орныхоо төлөө  
Ард олныхоо төлөө  
Аз жаргалынхаа төлөө  
Ач үрсийнхээ төлөө  
Алтан амиа хайрлаагүй  
Ариун цусаа харамлаагүй  
Тэмцэж ялсаар эрэлхэг нөхөцсөн  
Тийм л гавьяатай дарга даа.

*БНМАУ-ын Дархан хил хязгаарыг хамгаалах дайчин цогтой хэрэгт  
баатарлаг гавьяа байгуулсан учир Ховд аймгийн Чандмана сумын  
харьяат Баянбалын Тэгшээ, Хөвсгөл аймгийн Бүрэн сумын  
харьяат Лхүндэвийн Даваадорж, Булган аймгийн Сайхан сумын  
ард Самданжамцын Лхагвадорж нарт БНМАУ-ын Бага Хурлын  
Тэргүүлэгчдийн 1949 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 6 дугаар  
тогтоолоор БНМАУ-ын баатар цолууд нэхэн шагнасан билээ.*

## ТӨГСГӨЛ БЯЦХАН ШҮЛЭГ

Эх орныхоо төлөө  
Эцсийн амьсгалаа зориулсан  
Эрэлхэг зоригт баатруудыг  
Элэг зүрхэндээ бишрэв үү?  
Монгол улсынхаа төлөө  
Монгол түмнийхээ төлөө  
Энх жаргалаа хамгаалж  
Эрх чөлөөгөө өмгөөлж  
Этгээд ширүүн шалгалт бүхнийг  
Эд нар туулан давснаас  
Эрин улиравч, түүхнээ мөнхрөх  
Эрхэм тод мөрөө үлдээсэн  
Энхрий хайрт хөвгүүдээ  
Эх орон нам засаг нь  
Эр цэргийн  
Эрдэм мэдлэгт 5  
Эх орны  
Даалгавар биелүүлэхэд 5  
Эрс хатуу  
Сахилга батаараа 5  
Эрч хүч  
Байлдааны чадвараар 5  
Эцэж цуцахгүй  
Агуу зүтгэлээрээ 5  
Эх оронч,  
Ариун сэтгэлээрээ 5  
Эрэлхэг чин  
Зориг хатуужлаараа 5  
Эцсээ хүртэл  
Үнэнч шударгаараа 5  
Бүх дүнгээрээ 5 гэж  
Бүрэн үнэлэн дүгнэж  
БНМАУ-ын  
Баатар болгосон юм.

*1968 он*

## 1969 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл

*Д. Содномдорж*

*ҮНЭНЧ ЗҮРХ*

*Редактор Ж. Шагдар*

*Зураач Д. Доржнамжим*

*Зургийн редактор Д. Сандагдорж*

*Техник редактор Б. Алтансаргай*

*Хянагч Ч. Бадамхатан, Б. Цэдэндорж*

*А—34696.*

*Өрөлтөд 1968—10—25-нд*

*Хэвлэлтэд 1969—2—25-нд.*

*Цаасны хэмжээ 70x108 1/32*

*Хэвлэлийн хуудас 3,25.*

*Хэв. нэгж хуудас 4,55*

*Хэвлэсэн тоо 6000*

*Зах № 60*

*Үнэ .*

*Хэв. газ. № 204/68*

*БНМАУ-ын Ардын Боловсролын Яамны хэвлэл.*

*Д. Сүхбаатарын нэрэмжит хэвлэлийн комбинатад хэвлэв.*

*Улаанбаатар. Сүхбаатарын талбай, 2.*



**БОЛОР ДУРАН 2.0**  
АЛДАА ШАЛГУУР

## "БОЛОР ДУРАН" ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ ПРОГРАМ

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.

